



ЭРЧИМ

МЭДЭЭ

№02 (153)

2024 оны 02-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

**"ДЦС-4" ТӨХК-ийн
Залуучуудын холбооны
ээлжит чуулган боллоо**

2-р нүүрт

**2024 ОНЫ 2-Р
САРЫН ТЭЗҮ**

3-р нүүрт

**2024 ОНЫ 2-Р САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

4-р нүүрт

**САНАЛ САНААЧЛАГААРАА
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН
ТАЙЛАН**

5-р нүүрт

**МВС-2024-ийн ӨНГИЙГ
ТОДОРХОЙЛСОН
ТЕХНОЛОГИУД**

6-р нүүрт

**"Д" АМИНДЭМИЙН
ХЭРЭГЛЭЭ, АЧ
ХОЛБОГДОЛ**

7,8-р нүүрт

ЛУУ ЖИЛИЙН САР ШИНИЙН ЗОЛГОЛТ БОЛЛОО

XVII жарны "Хилэнт эх" хэмээх модон луу жилийн Цагаан сарын нийт ажиллагсдын золголтын үйл ажиллагаа 2024 оны 02-р сарын 13-ны өдөр буюу шинийн 4-ний билэгт сайн өдөр зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээнд СУИС-ын багш Морин хуурч А.Алтанбат, Уртын

дууч Б.Номин-Эрдэнэ нарыг оролцуулан нээлтийн арга хэмжээг зохион байгуулан урлагийн мэндчилгээ дэвшүүллээ. Золголтын арга хэмжээнд компанийн удирдлагууд болон ажилтан ажиллагсад 300 гаруй хүн оролцсон байна.



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, sxa@tpp4.mn эсвэл

СХА-нд файлаар болон бичгээр өгч болно.



www.tpp4.mn

"ДЦС-4" ТӨХЖ-ИЙН ЗАЛУУЧУУДЫН ХОЛБООНЫ ЭЭЛЖИТ ЧУУЛГАН БОЛЛОО

2024 оны 2 сарын 28-ны өдөр компанийн Залуучуудын холбооны ээлжит чуулган Дөл танхимд боллоо. Чуулганаар Залуучуудын холбооны 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах, Залуучуудын холбооны тэргүүнийг сонгох үйл ажиллагаа

боллоо. Залуучуудын холбооны тэргүүнээр СХА-ны Үйлдвэрлэлийн зурагзүйн инженер Л.Мягмарсүрэн сонгогдож, тамга, тэмдэгээ гардан авлаа.

Шинээр сонгогдсон тэргүүндээ залуучуудын төлөөх ажил үйлсэд нь амжилт хүсье.





2024 ОНЫ 2-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Диспетчерийн төлөвлөгөөт даалгаварыг **9113,396** мян.кВтц цахилгаан эрчим хүчээр давуулан биелүүлж, **3933,453** мян.кВтц-аар зөрчиж төлөвлөгөөг **5179,943** мян.кВтц-аар давуулан биелүүллээ. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал **580** МВт, дээд ачаалал **746** МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт, %
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	412.5	417.7	+5.2	101.3%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	624.2	624.2	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ – 101.3%, ДЭХ – 100.0% биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Удаа	мян.кВтц	Дээд	Доод	мян.кВтц	мян.кВтц
73	8446.422	20	3667.417	4	1922.993	747	573	6523.429	-

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд **394,647** мян.кВтц буюу **16,5** сая. төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, СПОТ зах зээлээс **339,354** мян.кВтц буюу **12,9** сая.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж авсан. Авлага өглөгийн зөрүүгээр **3,6** сая.төгрөгний ашигтай ажилласан. Өссөн дүнгээр манай станц **12,9** сая.төгрөгний авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс **17,4** сая. кВтц-аар давуулан **104,4%**-н биелэлттэй, оны эхнээс **31,4** сая.кВтц-аар давж, **103,7%**-ийн биелэлттэй байна. Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 2-р сартай харьцуулбал **20,6** сая.кВтц буюу **5,2%**-н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт **37,5** мян.Гкал-аар өсч **106,4%**-н биелэлттэй, оны эхнээс үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө **20,6** мян. Гкал-аар, үүнээс “УБДС” ХК –д нийлүүлэх дулаан **16,8** мян.Гкал –аар давсан байна. Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 2-р сартай харьцуулбал **74,7** мян.Гкал буюу **13,6** %-н бууралттай байлаа.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Тайлант сард **8** зуух, **7** турбины горимоор **9** хоног, **7** зуух, **7** турбины горимоор **9** хоног, **6** турбины горимоор **9** хоног ажиллах төлөвлөгөөтэй байсан. Хэрэглээтэй уялдан ДҮТ ХК-н захиалгаар **8** зуух, **7** турбинтэй **17** хоног, **7** зуух, **7** турбинтэй **12** хоног ажиллалаа. ЦЭХ-ний боловсруулалт өнгөрсөн оны 2 сартай харьцуулахад **23,7** сая.кВтц-аар өссөн бөгөөд өсөлтийн **61,6%** нь шөнө буюу 0–8 цагт, **19,3%** нь 8–16 цагт, **19,1%** нь 16–24 цагуудад нэмэгджээ.

Мазутын зарцуулалт

Энэ сард **100** тонн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс **158** тонн мазут түлж **58** тонн-оор хэтрүүлсэн. Тайлант хугацаанд **8** удаагийн хүйтэн галлагаанд **155** тн мазут, **1** удаагийн халуун галлагаанд **3** тонн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар **19** тн мазут зарцуулсан байна. Зуухны зогсолт олон байснаас мазут зарцуулалт хэтэрсэн.

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	205.0	206.032	+1.032	100.5%
Шивээ-Овоо	мян.тн	190.0	207.980	+17.980	109.5%

Бүгд	мян.тн	395.0	414.012	+19.012	104.8%
------	--------	-------	---------	---------	--------

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг – **2,65** гр/кВтц-аар хэтрүүлж, дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлшийг – **0,393** кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс **862** тн жишмэл түлш буюу **1861** тонн бодит түлш /илчлэг **3238** ккал/кг/ хэтрүүлсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ-аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг төлөвлөсөн хэмжээнд барьж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	2-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/тн.нүүрс	27.54	27.53
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/тн.уур	4.40	4.40
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/тн.тэж ус	7.25	7.25
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	0.94	0.94
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.66	0.66

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг **0,3%** – аар буюу **6937** тонноор хэмнэсэн. Осмосын халаагч уурын зарцуулалт **4516** тн байлаа. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт **4703** тонноор буурсан.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд – **9981** м³ ус
- Зууханд – **665** м³ өгсөн
- БКБ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт – **20702** м³ байлаа.



2024 ОНЫ 2-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2024 оны 02-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 10 бүртгэгдсэнээс зуух 9 удаа, турбин 1 удаа зогссон. Хүний буруутай үндсэн тоноглолын зогсолт гараагүй.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2023 оны 2-р сар	2024 оны 2-р сар	2023 оны 2-р сар	2024 оны 2-р сар	2023 оны 2-р сар	2024 оны 2-р сар	2023 оны 2-р сар	2024 оны 2-р сар	2023 оны 2-р сар	2024 оны 2-р сар
1	Зуух	-	-	1	4	-	-	-	5	1	4
2	Турбин	-	-	2	1	-	-	1	-	3	1
	Дүн	-	-	3	5	-	-	1	5	4	10

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Мазут зарцуулалтын акт:	ЗЦ-5 (177,575,207.21₮),	Бүгд-5 (177,575,207.21₮)
- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт:	ЦЦ-1 (577,500₮),	Бүгд-1 (577,500₮)
- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт:	ТДЦ-2 (0₮),	Бүгд-2 (0₮)
Нийт 8 ширхэг (178,152,707.21₮) акт тогтоогдсон.		

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °С)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2023 оны 02-р сар	2024 оны 02-р сар	2023 оны 02-р сар	2024 оны 02-р сар	2023 оны 02-р сар	2024 оны 02-р сар	2023 оны 02-р сар	2024 оны 02-р сар	
1	ТДЦ	75,5	82,9	10,8	9,5	36,0	40,5	13,8	13,92	+0,12
2	ЗЦ	84,5	83,1	22,0	24,9	22,5	18,8	9,7	10,58	+0,88
3	ТЦ	81,9	82,6	23,7	28,1	22,3	19	11,75	12,25	Станцын дундаж тоосролт
4	ЦЦ	-	51,7	-	24,3	-	15,2			
5	Хими	76,5	77,6	20,0	20,6	23,3	22,6			
6	Механик	96,9	89,5	19,3	18,1	19,1	24			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр			
№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	21 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	22 ажлын байранд эргэлт шалгалтын маршрутын дагуу хяналт тавьсан. ТДЦ дээр дотоод аудит хийсэн. ТЦ, ЦЦ -үүдэд ХАБ-ын нэгсэн үзлэгээр ажлын байруудад үзлэг хийсэн. 7 цехэд ХАБ-ын 3-р шатны үзлэг хийсэн.
2. Сургалт, зааварчилгаа			
1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	37 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	-	20 ажилтан зааварчилгаа өгч аюул, эрсдэл, хөдөлмөрийн нөхцлийн талаар ярьж өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	9 ажилтнаас шалгалт авсан.
4	Бусад сургалтын талаар	100%	Зэрэг ахих болон жинхлэх 15 ажилтнаас шалгалт авсан.
3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар			
1	МХЕГ ХАБУЛ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	Гэрээ хийгдэж гарын үсэг зурагдаж байгаа.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн 6 цехд хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийгдсэн.
3	Ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт тавьсан талаар	100%	Хяналт тавьж байгаа
4	Ариутгал халдваргүйтгэл шавьж мэргэчийн устгал хийсэн талаар	100%	Хяналт тавьж байгаа
5	Тоосролтын хэмжилтэнд хяналт хийсэн байдал	100%	Нийт 4 удаа хэмжилт хийгдсэн. Хэмжилт хийх явцад хяналт тавьж байгаа./
4. Бусад ажлын талаар			

- ТДЦ дээр ISO 45001:2018 ХЭМАБ-ын стандартын хэрэгжилтэнд дотоод аудит хийж тайлан, залруулах арга хэмжээ, зөвлөмж гаргаж өгсөн.
- ЭХЯ -с ирсэн ОМД-1 гүйцэтгэл гаргаж, яаманд хариу гаргаж явуулсан.
- Станцын осол эсэргүүцэх дасгал хийх хөтөлбөр гаргаж ЦЦ дээр ОЭД зохион байгуулсны дагуу гүйдэлд нэрвэгдсэд үзүүлэх анхны тусламж үзүүлэх зөвлөмж Эмнэлэгтэй хамтран гаргаж тараалт хийсэн.
- ТЦ, ЦЦ -р ХАБ-ын нэгдсэн үзлэг хийгдсэний дагуу залруулах төлөвлөгөө гаргасан.

- ХАБ-ын 3-р шатны үзлэгийн нэгдсэн тайлан, төлөвлөгөө гаргаж тараасан.
- ТЦ, МЦ-р хүйтрэлтэй холбоотой үзлэг хийсэн.
- ХЭМАБ-ын үүрэг, хариуцлага, эрх мэдлийн хувиарлалт шинэчилж батлуулж тараалт хийсэн.
- Харуул хамгаалалтын хэсэгт дээд байгуулгаас шалгалтаар ирсэн албан тушаалтныг нэвтрүүлэх талаар албан шаардлага бичиж хүргүүлсэн.

MWC 2024-ИЙН ӨНГИЙГ ТОДОРХОЙЛСОН ТЭХНОЛОГИУД



Дэлхийн үүрэн холбооны операторууд, технологийн салбарын тоглогчдын хамгийн том цугларалт Mobile World Congress 2024 уламжлал ёсоор Испанийн Барселона хотноо хүн төрөлхтний өнөөдөр, маргаашийн олон сорилтуудыг шийдэхэд чиглэж “Эхлээд ирээдүй” сэдвийн дор болж өнгөрлөө.

Энэ жилийн арга хэмжээнд AI, 5G, 6G сүлжээ, зүйлсийн интернэт тэргүүтэй олон сэдэв хөндөгдөж, салбарын аваргууд шилдэг технологи, шалгарсан инновац, шинэлэг санаагаа танилцуулснаас манай редакц дараах таван бүтээгдэхүүнийг онцолж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН УХААЛАГ БӨГЖ: GALAXY RING



Galaxy Unpacked 2024-ийн үеэр хараа булаам шторкоо цацаж, өндөр хүлээлт үүсгэсэн Galaxy Ring-ийг бодитоор танилцуулав. Эрүүл мэнддээ анхаардаг хүмүүст зориулсан уг

бөгж нь зүрхний цохилт, амьсгалын тоо, нойрны чанар зэрэг гол үзүүлэлтүүдийг хянаж, шинэчлэгдсэн Samsung Health платформтой хоршин ажиллана. Товчхондоо оюун санаа, бие махбодын олон мэдээллийг цуглуулж, бүтээмжийг үнэлэн, амьдралын чанарыг хэмжих юм.

Тус ухаалаг бөгжийг энэ жил худалдаалахаар төлөвлөж байгаа бөгөөд хар, алтлаг, мөнгөлөг гэсэн гурван өнгөний сонголттой, есөн өөр хэмжээтэй байх юм. Мөн сонирхуулахад, Самсунг Электроникс компанийн дижитал эрүүл мэндийн багийн ахлагч Хон Пак цусан дахь сахрын хэмжээ, цусны даралтыг хэмжих технологийг өмсдөг төхөөрөмжид нэвтрүүлэхээр төлөвлөж буй гэв. Тэгж чадвал хэрэглэгч бид цусан дахь сахраа шалгах гэж өдөр бүр арьсаа зүүгээр цоолох шаардлагагүй болох юм.

100 ЦАГ АЖИЛЛАХ УХААЛАГ ЦАГ: ONEPLUS WATCH 2



Арга хэмжээний үеэр OnePlus компани Wear OS 2 үйлдлийн системтэй ухаалаг цагны хоёр дахь үе танилцууллаа. OnePlus Watch 2 нь 1,43 инчийн 326ppi дэлгэц, зэвэрдэггүй ган их биетэй, хоёр тусдаа үйлдлийн систем болон хоёр төрлийн чипээр тоноглогджээ.

Тус ухаалаг цаг нь хөдөлгөөн, нойр, байршил, зүрхний цохилт, цусан дахь хүчилтөрөгчийг хянах боломжтой. Зөвхөн нэг хэмжээтэй бөгөөд хар ган, цацрагт ган гэсэн хоёр өнгөтэй бөгөөд 70 хэмийн халуун, -40 хэмийн хүйтнийг тэсвэрлэх чадвартай гэнэ. Уг цагийг 299 ам.доллаароор худалдан авах боломжтой.

РОБОТ НОХОЙ: XIAOMI CYBERDOG 2



Xiaomi одоогоос гурван жилийн өмнө CyberDog-ийн санаагаа танилцуулсан бол энэ жилийн MWC арга хэмжээний үеэр сайжруулсан CyberDog 2-оо танилцууллаа.

Энэхүү робот нохой нь ухрах, унах, босох, нэг хөл дээрээ зогсох зэрэг хүндрэлтэй хөдөлгөөнүүдийг хийж чадна. Хиймэл оюун ухаанд суурилсан интерактив камер, дөрвөн ToF мэдрэгч, LiDAR мэдрэгч, гүний камер, хэт авианы мэдрэгч, сонсголын өндөр нарийвчлалтай 19 мэдрэгчтэй. Робот нохойг гар утасны программ, дуут удирдлага, алсын удирдлагаар удирдах бөгөөд дээд тал нь 1.6м/с хурдтай алхаж, 1кг ачаа даах чадалтай гэнэ.

ТУНГАЛАГ ДЭЛГЭЦТЭЙ ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР: THINKBOOK TRANSPARENT DISPLAY LAPTOP



Уран зөгнөлт киноноос л үзэж болох нэвт харагдах шидтэй, тунгалаг төхөөрөмжүүд бидний амьдралын эгэл хэрэглээ болж нэвтэрсээр. Энэ жилийн арга хэмжээний онцлох төхөөрөмжүүдийн

нэг бол яах аргагүй Lenovo-ийн тунгалаг дэлгэцтэй зөөврийн компьютер байв.

Гол давуу тал нь 17.3 инчийн MicroLED дэлгэц нь 55 хувь хүртэл нэвт харагдах үзүүлэлттэй. Угтаа энэ төрлийн технологи нь шинэ зүйл биш бөгөөд Самсунг корпораци гэхэд 10 гаруй жилийн өмнө CES 2010 үзэсгэлэнгийн үеэр ижил төрлийн төхөөрөмжийг үзүүлж байсан бол Zuk Mobile охин компаниараа дамжуулан тунгалаг дэлгэцтэй ухаалаг гар утас танилцуулж байв.

ЭКОСИСТЕМИЙН НЭГДЭЛ: XIAOMI ELECTRIC CAR



Xiaomi анхны цахилгаан машин болох Xiaomi SU7-ийг танилцуулсан нь цахилгаан тээврийн хэрэгслийн (EV) зах зээлд онцлох нээлт боллоо. Хараа булаам дизайн, гоёмсог цэнхэр өнгөөр ялгагдах уг спорт загвар 2.78 секундэд

100 км/цаг хурдлах хүчтэй, нэг цэнэглэлтээр 750 км замыг туулах чадвартай тул холын аялалд нэн тохиромжтой. Мэдээж төмөр хүлгийн хурд хүчнээс илүү Xiaomi-ийн эрхэм зорилго бол "Human x Car x Home" буюу экосистемийн нэгдэл юм. Энэ зорилгынхоо хүрээнд 200 гаруй төрлийн 600 сая төхөөрөмж хоорондын хоршлыг хөнгөвчлөх HyperOS үйлдлийн системээ танилцуулсан билээ. Бидний ажил, амьдралын хэв маяг, арга барил илүү хялбар, өндөр бүтээмжтэй болж өөрчлөгдөж буйг Мобайл конгресс 2024 тодхон харууллаа. Зөвхөн технологиор ч хязгаарлагдахгүй аж төрөхүйн бүх салбар хиймэл оюун ухаанаар амьсгалж, 5G сүлжээ дараагийн шатанд шилжиж буй энэ цагт тэднийг цогцоор нь нэгтгэх шаардлагатай байгааг оролцогчид онцолсон байна.

Одоогоор тэдний хувьд уг бүтээгдэхүүнээ хэрэглээний төхөөрөмж болгон гаргахаар төлөвлөөгүй боловч ойрын таван жилдээ бодит хэрэглээнд нэвтрүүлэх тухай Verge-д дурджээ.



САНАА САНААЧЛАГААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 2-р сард явцуу дамжлага арилгах чиглэлээр санал санаачлага гарган хийсэн дараах ажлуудыг танилцуулж байна. Үүнд:

1. ХУВИАРЛАХ ХУТГА ПС, СПС-ҮҮДИЙН ИНДУКЦИЙН ДАТЧИКАНД МЕХАНИК ГЭМТЛЭЭС ХАМГААЛСАН ХАМГААЛАЛТ ХИЙХ

Шаардлага: Хувиарлах хутгуудад нийт 38 ширхэг индукцийн датчик хэрэглэгддэг. Хутгыг буулгах, сөхөх ажиллагааны явцад жилд дундажаар 5 ширхэг датчик цохигдож гэмтдэг байсан тул хамгаалалт хийх шаардлагатай болсон.

Зардал: Хоёрдогч түүхий эдээс хаягдал лист төмөр авч хэрэглэсэн тул зардал гараагүй.

Ашиг: Нэг ширхэг индукцийн датчигны үнэ /ERP-д/ 227403 төгрөгийн үнэтэй бөгөөд 5x227403=1.137.015 төгрөгийн хэмнэлт гарна.

Санаачлага гарган ажилласан: ЦАЛ-ийн инженер Н.Алтанзул, ЦАЛ-ийн монтер Ц.Пүрэвжал, Г.Амарсанаа, Б.Батжаргал, Ц.Бумбаяр, Ц.Мөнх-Оргил



2. ГЕНЕРАТОР № 1-5 ЧАДЛЫН ХЭМЖҮҮРИЙН ТЭЖЭЭЛИЙН ХЭЛХЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ



Шаардлага: Чадлын хэмжүүрүүдийн тэжээлийн хэлхээг найдваржуулах

Зардал: 1. Автомат CHNT 2 фаз 10A DC 5 ш x 7800₮(ERP) = 39000₮

2. Кабель АВВГ 2,5x2 x 50 метр (хоёрдогч түүхий эдээс)

Ашиг: Тоноглолын найдвартай ажиллагаа сайжирсан.

Үр дүн: Чадлын хэмжүүрийн хувьсах тэжээлийг тогтмол тэжээлрүү шилжүүлсэнээр чадлын хэмжүүрийн заалт хяналтгүй болох, турбины тохируулгын системд ачаалал хязгаарладаг хүндрэлүүд үгүй болно.



Санаачлага гарган ажилласан: Хэмжүүрийн инженер Г.Энхбаатар

Зураг №1. Чадлын хэмжүүрийн тэжээлийг ШПТ№1,2 оос тэжээх будуувч схем болон PR300 хэмжүүрийн холболтын схемийг харуулав.

ТГ-1-6 –д суурилуулсан

PR300 чадлын хэмжүүрийн

тогтмол хүчдлээр ажиллах дээд доод хязгаар 130-300 V DC учраас газардлагатай холбоотой хүчдлийн хэлбэлзэлд хэмжүүр унтрах, буруу ажиллах хүндрэл үүсэхгүй. Хувьсах тэжээлд доголдол үүсэх, тодорхой хугацааны гэмтэл гарахад генераторын актив.

3. ЭСРЭГ ОСМОС №3,4-Т ЗОРИУЛАЛТЫН СОРЬЦЫН ЦЭГ ХИЙХ

Шаардлага: Эсрэг осмос №3,4 тус тусдаа ерөнхий нэг сорьцыг боловсруулсан усны шугамнаас татсан байсанг сайжруулан модуль тус бүрээс сорьцын цэг татах шаардлага гарсан.

Зардал: Ду-8 мм шланг 210 м, Ду-12 мм нерж труба – 4 кг, сорьцын хайрцаг – 2 ш, кабелийн коробка – 8 м, М6 боолт – 30 ш, сангийн лент –6 ш /Цехийн илүүдэлтэй бараанаас ашиглав./

Үр дүн: Эсрэг осмос №3,4 –н модуль тус бүрийг сорьцын цэгтэй болгосноор хими хяналт сайжирна, тоноглолын ажиллагааг хянах зэрэг давуу талууд бий болсон.

Санаачлага гарган ажилласан: А.Золбаяр, Б.Түвшинзаяа, Э.Намжин, Я.Ганзориг, Б.Оч-Эрдэнэ, Ч.Аравжай



4. ХААЛТНЫ БИТҮҮМЖ ШАЛГАДАГ СТЕНД ХИЙСЭН.

Шаардлага: Шинэ болон хуучин хаалтны битүүмж шалгадаг стэнд огт байхгүй.


Зардал: Одоо ашиглагдаж байгаа азотыг рампыг ашиглаж хийсэн.

Үр дүн: Засварын ажлын чанар сайжрах. Засварын ажлын цаг хугацаа хэмнэх.

Санаачлан хийсэн: Устөрөгч, аккумуляторын ашиглалтын мастер Р.Айболат, устөрөгчийн тоноглолын засварын монтер Т.Батзориг, Д.Дашням, аппаратчин, засварчин Б.Ням-Очир.

Азотын рампд хаалтны битүүмж шалгадаг стэнд шинээр хийж холбож байрлуулж ажилд оруулсан:

(ШБАЗ)



5. ТДЦ ТЭХ. ГАЗАР УХАХ ЦАХИЛГААН БАГАЖ

Шаардлага: Модон дэр, төмөр бетон дэр нь хоёр зам төмрийг буюу жиргээг 1520 мм царигт тохируулан бариж байдаг. Муудсан дэр модыг, газрын хөрсийг лап, лоомоор цохиж суллаж сольдог. Хуучин дэр модны газар нь галт тэрэгний хөдөлгөөнд удаан байснаар маш хатуу нягтаршсан болдог тэрийг лап, лоомоор суллаж цохиход замчдаас ихээхэн хүч, цаг хугацаа шаарддаг.

Зардал: Хуучин актласан байсан лапны үзүүрийг тайрч авч хийсэн. Суурь төмрийг 10мм-ийн лист төмрийг дөрвөлжиж бэлдэн суурь, лапны үзүүрийг хооронд нийлүүлж гагнасан.

Үр дүн: Хуучин модон дэрний доорх газар нь хөдлөх бүрэлдэхүүн дээгүүр явсаар, маш хатуу нягтаршсан байдлыг замчид лап, лоомоор цохидог байсныг шинээр цахилгаан газар ухагч /молоток/ өөрсдийн ашигладаг багажинд суурьлуулж хийснээр хугацаа хэмнэж ажлын бүтээмж дээшилж байна.

Ашиг: Төмөр замын дэлгэмэл урт 18,5 км урт. Нэг км замд ойрлцоогоор 1840 дэр мод байдаг.


18,5 км * 1840 м/д, ТБД= 34.040 модон дэр болон төмөр бетон дэр байдаг.

Нэг ширхэг модон дэр солиход 1,53 хүн/цаг, төмөр бетон дэрийг солиход 2,1 хүн/цаг хугацаа зарцуулдаг.

Санал саначлагаар хийсэн цахилгаан ухагчтай /молоток/ болсноор нэг ширхэг модон дэр солиход 1,23 хүн цаг, төмөр бетон дэр солиход 1,9 хүн/цаг зарцуулж байна.

Ингэснээр модон дэр дээр 0,3 хүн/цаг хэмнэлт, төмөр бетон дэрэн дээр 0,2 хүн/цаг хэмнэлт хийж ажлын бүтээмжийг дээшлүүлсэн

Санаачлан хийсэн: Зам засварын инженер Б.Батболд, Ахлах замчин Э.Жвхлан, Замчин Д.Осоржамаа, Г.Ганзоирг, Б.Төгсбуян, Г.Билгүүн



СХА-Н/ Патентийн мэргэжилтэн Ч.Баясгалан



"Д" АМИНДЭМИЙН ХЭРЭГЛЭЭ, АЧ ХӨЛБӨГДӨА

Хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тосонд уусдаг витамин ба хоол хүнсээр хүний биед орохоос гадна нарны хэт ягаан туяа /Ultraviolet В/ - ны нөлөөгөөр арьсан доор нийлэгждэг цорын ганц аминдэм юм.

Д аминдэмээр баялаг хүнсний хэрэглээ хангалтгүй байх, наранд ил байх хугацаа багассаны улмаас уг аминдэмийн дутал дэлхийн хүн амын дунд түгээмэл тохиолдож байна. Хүйтэн уур амьсгалтай өндөр өргөргийн бүс, агаарын бохирдол ихтэй орчинд амьдрах, нарнаас хамгаалах хэрэгсэл (нарны тос, саравч, сүүдрэвч)-ийг өргөн ашиглах, бараан өнгийн арьстай байх, өдрийн ихэнх цагийг дотоод орчинд өнгөрүүлэх зэрэг хүчин зүйл нь нарны хэт ягаан туяаны нөлөөгөөр Д аминдэмийг нийлэгжүүлэх хүний бие махбодын чадварт сөргөөр нөлөөлж байна. Эдгээр нь нарны хэт ягаан туяа хүний биед шингэх боломжийг хааж, улмаар Д аминдэмийг нийлэгжүүлэх чадавхийг хязгаарладаг. Уг аминдэм нь кальцийн шимэгдэлт болон яс, булчингийн хэвийн үйл ажиллагаа, дархлалын тогтолцоонд чухал нөлөөтэй байдаг. Жирэмсэн үе, нярай, бага болон өсвөр насны хүүхдийн эрчимтэй өсөлтийн үед ясны хэвийн өсөлтийг хангах, кальцийг биед шингээх, дархлааг сайжруулах, зүрх судасны тогтолцооны хэвийн үйл ажиллагааг хангах зэрэгт Д аминдэмийн хэрэгцээ эрс нэмэгддэг.

ХҮН АМЫН ДУНДАХ Д АМИНДЭМ ДУТЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улс дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст байрладаг тул суурин оршин суугчид жилийн ихэнх хугацаанд наранд биеэ ил гаргах боломжгүй байдгийн зэрэгцээ нарны

ташуу тусгалын улмаас биед шингэх хэт ягаан туяаны эрчим арьсан дор байгаа Д аминдэмийн урьтал бодисыг идэвхтэй хэлбэрт шилжүүлж, Д аминдэм нийлэгжих хангалттай түвшинд хүрч чаддаггүй байна. Мөн өвлийн улиралд агаарын бохирдол ихтэй байдаг нь хэт ягаан туяаны шингээлтийг бууруулдаг ба ийнхүү жилийн ихэнх хугацаанд буюу 9 сард нь нарны туяаны нөлөөгөөр Д аминдэмийг нийлэгжүүлэх боломжгүй, монголчууд Д аминдэмээр баялаг хүнсийг тогтмол хэрэглэдэггүй, зах зээлд Д аминдэмээр баяжуулсан хүнсний хангамж бага байдаг, Д аминдэмээр баялаг болон баяжуулсан хүнсийг хангалтгүй хэрэглэдэг зэргээс шалтгаалан Монгол хүн Д аминдэмийн дуталд өртөх эрсдэл өндөр байна.


“Хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний V судалгааны дүнгээр Д аминдэмийн дуталд өртөх өндөр эрсдэлтэй бүлэг болох 5 хүртэлх насны хүүхэд, 15-49 насны эрэгтэйчүүд, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд уг аминдэмийн дутал түгээмэл тархалттай байгааг тогтоов.

Тодруулбал, 6-59 сартай хүүхдийн 61 хувь Д аминдэм дуталтай, 29 хувь нөөц багатай буюу нийт хүүхдийн 90 орчим хувь Д аминдэмийн хангамж хангалтгүй байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 75 хувь Д аминдэм дуталтай, 20 хувь нөөц багатай буюу нийт эмэгтэйчүүдийн 95 хувьд Д аминдэм хангалтгүй түвшинд байна. 15-49 насны эрэгтэйчүүдийн 80-аас илүү хувь нь Д аминдэм хангалтгүй болон нөөц багатай байгаа нь анхаарал татаж байна. Зүрх судасны өвчин Монгол Улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өнөө үед насанд хүрэгчид, хүүхдийг Д аминдэм дутлаас сэргийлэх, Д

аминдэмийн хангамж, хүртээмжийг сайжруулах нь нийт өвчлөл, нас баралтыг бууруулах алсын үр дүнтэй арга байж болох юм гэж судлаачид үзэж байна.

Хүний бие махбод дахь Д аминдэмийн түвшин хангалтгүй байх нь ясны эрдэсжилтэд сөргөөр нөлөөлж, хүүхдийн өсөлт хоцрох, насанд хүрэгчдийн яс зөөлөрч сийрэгжин хугарах, аливаа халдварт өртөх эрсдлийг нэмэгдүүлдэг байна. Д аминдэм дутлын улмаас хүүхдэд рахит өвчин үүсэх бөгөөд хүүхдийн яс зөөлрөх, ясны хэлбэр өөрчлөгдөх шинж (майга эсвэл Х хэлбэрийн хөл гэх мэт)-ээр илэрдэг.

Түүнчлэн Д аминдэм дуталтай холбоотойгоор дархлаа сулрах, цусны даралт ихсэлт, чихрийн шижин, зарим эрхтэний хавдар зэрэг архаг өвчнөөр өвчлөх эрсдэл нэмэгддэг. Илүүдэл жинтэй, тарган хүний биед агуулагдах илүүдэл өөх нь Д



аминдэмийн шимэгдэлт, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлдэг тул Д аминдэмийн дуталд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Д аминдэмийн дуталд өртөх өндөр эрсдэлтэй хүн амын бүлэгт тухайн аминдэмийн хэрэгцээ ихтэй жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, нялх, бага насны хүүхэд, эрчимтэй өсөлтийн үедээ байгаа хүүхдүүд багтдаг. Нас ахих тусам арьсны нарнаас D витамин шингээж авах чадвар тодорхой хэмжээгээр буурдаг, наранд ил гарах хугацаа бага зэрэг шалтгааны улмаас Д аминдэмийн дуталд өртөх эрсдэл нэмэгддэг байна. Өнөө үед Д аминдэм нь зүрхний цус хомсрох өвчнөөс сэргийлэхэд шийдвэрлэх үүрэгтэй болохыг нотолсон байна. Хүний бие дэх Д аминдэмийн түвшин хангалттай байх нь зүрхний шигдээсээр өвчлөх, нас барах эрсдэлийг бууруулдаг аж.

Витамин Д нь ихэвчлэн далайн гаралтай хүнс болох түүхий эд, загасны тос, яргай загас, мөөг, өндөг, сүү, амуу, буудай, элэг, туна загас, цөцгийн тосонд их хэмжээтэй агуулагддаг.

Д витаминг гурван аргаар авах боломж байдаг.

- Нарны хэт ягаан туяаны үйлчлэлээр
- Хоол хүнсээр
- Ууж хэрэглэх

Манай орны хувьд газарзүйн байршилтай холбоотойгоор нарны хэт ягаан туяаны үйлчлэлээр авах боломж бол хомсыг дээр дурьдсан. Мөн хоол хүнсээр авъя гэхэд манайд Д витаминаар баялаг хоол хүнс манай оронд тийм ч элбэг биш учраас бидэнд нэмэлтээр уух л сонголт байгаа юм. АНУ-ын эрдэмтэн Майкл Холик Д витаминаар судалгааны ажил хийсэн ба өдөрт авах хэмжээг хүүхдэд 1000-2000 ОУН, том хүнд бол 3000-5000 ОУН авах шаардлагатай гэж зөвлөсөн байдаг.

Шинжилгээ: Цусны шинжилгээгээр Д аминдэмийн хэмжээг тодорхойлдог.

Цусны ийлдэс дэх Д аминдэмийн түвшин, түүний үнэлгээ

Үнэлгээ	Д аминдэмийн хэмжээ
Д аминдэм дутал	<20 нг/мл
Д аминдэмийн нөөц багатай	20-29 нг/мл
Д аминдэмийн түвшин хангалттай	30-100 нг/мл
Д аминдэмийн илүүдэл /Хордох эрсдэлтэй түвшин/	>100 нг/мл

Шинжилгээний үндсэн дээр эмч эмчилгээний болон урьдчилан сэргийлэх тунгийн хэмжээг зөвлөсний дагуу ууна. Дур мэдэн өөрсдөө уух хэмжээг тохируулахгүй гэдгийг сайн ойлгох хэрэгтэй.

Витамин Д-н дутагдлаа хэрхэн нөхөх вэ?

- 01 Витамин Д-н шинжилгээ өгөх
- 02 Эмчилгээний буюу нөхөх тун уух
- 03 Барих буюу өдөр тутмын тунгаар уух
- 04 Жилд нэг удаа давтан, хяналтын шинжилгээ өгч байх

Ашигласан материал: "Хүн амын хоол тэжээлийн байдал" үндэсний V-р судалгаа, Innovation анагаах ухааны сэтгүүл

That Might Motivate You №18

Улаанбаатар хот
БГД, 20-р хороо
Эрчим хүчний гудамж

Утас: 7017-3097

Дугаарыг эрхэлсэн: Ч.Баясгалан
Хэвлэлтэнд өгсөн: 2024.03.07